

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/110/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: Saranchimeg.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
Залруулсан алдаа.....	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/66
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Дэлгэрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн тайлангаас зөрүүтэй, хөрөнгийн зардлаас бараа материал бэлтгэсэн мөн бараа ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн, нийтийн эзэмшлийн байгууламжийн ногоон байгууламжийг үндсэн хөрөнгийн бусад хөрөнгөнд бүртгэж элэгдэл байгуулсан мөн бусад хангамжийн материалд бүртгэсэн, төрийн мэдлийн газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй, хуульд заагаагүй нэмэгдлийг улс төрийн албан хаагчдад олгосон, төлбөрийн шилжүүлсэн дүн цахим баримтын дүнгээс зөрүүтэй, төсвийн хөрөнгөөр сум байгуулагдсаны 100 жилийн ойн медаль тэмдэг авсан зэрэг нийт 378,067.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

018000400

санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр 789,787.5 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 1,353,703.7 мянган төгрөгийн хөрөнгийг сайжруулалт болон үндсэн хөрөнгөнд орлого авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хуралдаанаар 2023 онд сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх “Дэлгэрхаан 100 хөгжлийн сангийн журам”-ыг баталсан байна.

Баяр наадмын талбайг цогцоор нь шинэчлэн барих 178,898.5 мянган төгрөгийн өртөгтэй тендерийн ажлыг Үржих тээвэр ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан байна. Сумын 100 жилтэй холбоотой хандиваар болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн сумын үүд 75,600.0 мянган төгрөг, Цомцог гэр 20,000.0 мянган төгрөг, 5-10 ханатай 5 гэр 15,000.0 мянган төгрөг, хүлээн авалтын сандал 21,450.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг орлого авсан.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	156,298,691.14	80,093,516.44
33	АВЛАГА	7,000,000.00	7,000,000.00
33500	Бусад авлага	7,000,000.00	7,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	7,000,000.00	7,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	149,298,691.14	73,093,516.44
35400	Хангамжийн материал	130,298,691.14	54,093,516.44
35410	Бичиг хэргийн материал	85,000.00	31,300.00
35420	Аж ахуйн материал	29,580,491.14	7,574,816.44
35430	Сэлбэг хэрэгсэл	3,389,000.00	0
35440	Түлш, шатах тослох материал	0	250,000.00
35470	Бусад хангамжийн материал	97,244,200.00	46,237,400.00
35600	Мал амьтад	19,000,000.00	19,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,175,008,775.42	3,245,807,853.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,175,008,775.42	3,245,807,853.07
39200	Биет хөрөнгө	1,174,131,775.42	3,201,956,999.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	994,266,017.07	2,560,284,096.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	-295,462,493.77	-317,608,381.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	270,969,151.00	400,904,551.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-198,487,111.29	-208,671,474.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	136,922,516.17	137,296,707.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,257,122.72	-92,636,349.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,497,685.00	65,733,860.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,043,203.58	-26,285,582.42
39210	Хуримтлагдсан элэгдэл	-112,052,600.94	-118,573,298.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	317,207,182.00	670,595,516.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-49,095,783.52	-67,750,184.45
39300	Биет бус хөрөнгө	877,000.00	43,850,854.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,255,000.00	-2,292,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,662,000.00	46,804,282.50
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,310,000.00	-3,440,928.45
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,331,307,466.56	3,325,901,369.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	935,262,210.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	935,262,210.00
41300	Өглөг	0	935,262,210.00
41360	Бусад өглөг	0	935,262,210.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	935,262,210.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,331,307,466.56	2,390,639,159.51
51	Засгийн газрын хувь оролцоо	1,331,307,466.56	2,390,639,159.51
51200	Хуримтлагдсан үр дүн	444,994,722.85	1,504,326,415.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-11,580,060.70	444,994,722.85
51220	Тайлант үеийн үр дүн	456,574,783.55	1,059,331,692.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,331,307,466.56	3,325,901,369.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,245,369,650.00	2,049,925,575.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	465,315,250.00	531,097,555.00
120	Нийтлэг татварын бус орлого	465,315,250.00	531,097,555.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	413,069,250.00	531,097,555.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	52,246,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	780,054,400.00	1,518,828,020.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,136,300.00	113,085,592.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	57,072,300.00	97,135,118.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	1,064,000.00	15,950,474.58
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	721,918,100.00	1,405,742,427.49
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	721,918,100.00	1,405,742,427.49
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	788,794,866.45	790,405,220.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	564,151,706.45	717,291,520.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,043,571.94	702,767,321.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,390,176.49	341,797,859.38
210101	Үндсэн цалин	151,861,100.00	281,842,135.63
210102	Нэмэгдэл	39,529,076.49	59,955,723.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,328,500.00	47,413,684.00
210201	Тэтгэврийн даатгал	26,328,500.00	47,413,684.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,253,583.00	45,469,849.88
210301	Гэрэл, цахилгаан	9,484,296.00	13,456,928.21
210302	Түлш, халаалт	27,599,287.00	31,812,921.67
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,007,800.00	27,277,800.00
210401	Бичиг хэрэг	2,132,500.00	2,039,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,452,800.00	19,677,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,422,500.00	2,560,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,740,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	11,740,000.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,757,200.00	4,634,000.00
210702	Дотоод албан томилолт	2,757,200.00	4,634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,808,006.00	14,332,983.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	32,661,406.00	13,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	259,800.00	99,297.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,800.00	246,686.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,000.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,758,306.45	211,841,144.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,927,600.00	141,567,294.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,830,706.45	70,273,850.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,108,134.51	14,524,199.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,065,400.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,800,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,265,400.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	55,042,734.51	12,524,199.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,054,234.51	12,524,199.31
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,988,500.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	224,643,160.00	73,113,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	224,643,160.00	73,113,700.00
221001	Их засвар	224,643,160.00	73,113,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	456,574,783.55	1,259,520,354.65
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	200,188,661.70
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0	200,188,661.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	456,574,783.55	1,059,331,692.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	780,054,400.00	1,518,828,020.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	780,054,400.00	1,518,828,020.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,136,300.00	113,085,592.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	57,072,300.00	97,135,118.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	1,064,000.00	15,950,474.58
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	721,918,100.00	1,405,742,427.49
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	721,918,100.00	1,405,742,427.49
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	467,289,600.00	647,017,669.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,289,600.00	647,017,669.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,181,465.49	632,493,470.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,390,176.49	341,797,859.38
210101	Үндсэн цалин	151,861,100.00	281,842,135.63
210102	Нэмэгдэл	39,529,076.49	59,955,723.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,328,500.00	47,413,684.00
210201	Тэтгэврийн даатгал	18,527,400.00	32,241,282.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,950,300.00	3,793,074.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,560,200.00	3,034,364.00
210204	Ажилгүйдлийн даатгал	390,100.00	758,716.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,900,500.00	7,586,248.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,253,583.00	45,469,849.88
210301	Гэрэл, цахилгаан	9,484,296.00	13,456,928.17
210302	Түлш, халаалт	27,599,287.00	31,812,921.71
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,008,000.00	27,277,800.00
210401	Бичиг хэрэг	2,132,500.00	2,039,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,453,000.00	19,677,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,422,500.00	2,560,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,740,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	11,740,000.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,757,200.00	4,634,000.00
210702	Дотоод албан томилолт	2,757,200.00	4,634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	34,162,206.00	14,332,983.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	33,015,606.00	13,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	259,800.00	99,297.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,800.00	246,686.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,000.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,541,800.00	141,567,294.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,541,800.00	141,567,294.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,108,134.51	14,524,199.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,065,400.00	2,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,800,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,265,400.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	55,042,734.51	12,524,199.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,054,234.51	12,524,199.31
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,988,500.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-	312,764,800.00	871,810,350.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	312,764,800.00	871,810,350.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	312,764,800.00	871,810,350.50
2200	Дотоод эх үүсвэрээр	312,764,800.00	871,810,350.50
220001	Барилга байгууламж	170,423,000.00	0
222001	Тоног төхөөрөмж	4,100,000.00	14,829,600.00
223001	Бусад хөрөнгө	78,581,800.00	67,193,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,660,000.00	789,787,550.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-312,764,800.00	-871,810,350.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-11,580,060.70	874,732,683.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-11,580,060.70	874,732,683.01
9	Тайлант үеийн үр дүн	0	0	456,574,783.55	456,574,783.55
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	444,994,722.85	1,331,307,466.56
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	444,994,722.85	1,331,307,466.56
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	444,994,722.85	1,331,307,466.56
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,059,331,692.95	1,059,331,692.95
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	1,504,326,415.80	2,390,639,159.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,672,107,900.00	1,402,272,391.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	901,415,400.00	530,462,041.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	899,415,400.00	528,462,041.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,808,700.00	327,445,408.21
210101	Үндсэн цалин	300,953,900.00	281,842,135.63
210102	Нэмэгдэл	57,854,800.00	45,603,272.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	44,851,200.00	45,131,500.00
210201	Тэтгэврийн даатгал	30,498,800.00	30,689,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,588,100.00	3,610,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,870,400.00	2,888,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	717,700.00	722,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,176,200.00	7,221,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,745,800.00	45,469,849.88
210301	Гэрэл, цахилгаан	13,693,400.00	13,456,928.17
210302	Түлш, халаалт	37,852,400.00	31,812,921.71
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,277,800.00	27,277,800.00
210401	Бичиг хэрэг	2,020,000.00	2,039,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,677,800.00	19,677,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,580,000.00	2,560,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,298,400.00	4,634,000.00
210702	Дотоод албан томилолт	5,298,400.00	4,634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	14,646,600.00	14,332,983.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	13,500,000.00	13,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	259,800.00	99,297.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,800.00	246,686.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,000.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	386,786,900.00	54,170,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	386,786,900.00	54,170,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,770,692,500.00	871,810,350.50
220001	Барилга байгууламж	1,534,547,200.00	763,847,151.50
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	14,829,600.00
223001	Бусад хөрөнгө	221,145,300.00	93,133,599.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,672,107,900.00	1,402,272,391.59
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,025,971,800.00	1,402,272,391.59
320001	Орон нутгийн төсвөөс	2,025,971,800.00	1,402,272,391.59
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	646,136,100.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	646,136,100.00	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	47	47
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,136,300.00	113,085,592.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,136,300.00	113,085,592.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,347,800.00	104,031,429.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	14,352,451.17
210102	Нэмэгдэл	0	14,352,451.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	2,282,184.00
210201	Тэтгэврийн даатгал	0	1,551,882.00
210202	Тэтгэмжийн даатгал	0	182,574.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	146,064.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0	36,516.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0	365,148.00
2104	Хангамж, бараа материалын зардал	972,000.00	0
210402	Тээвэр, шатахуун	972,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,375,800.00	87,396,794.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,375,800.00	87,396,794.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,788,500.00	9,054,163.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,800,000.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,800,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,988,500.00	9,054,163.41
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0	9,054,163.41
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,988,500.00	0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,136,300.00	113,085,592.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,136,300.00	113,085,592.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,072,300.00	97,135,118.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,064,000.00	15,950,474.58
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 28 арга хэмжээтэй баталснаас нийт 98,22 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 оны 6 дугаар сарын 20-нд Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж цалингийн урьдчилгаа илүү олгосон 1,262.6 мянган төгрөг, улс төрийн албан хаагчид төрийн албаны нэмэгдэл олгосон 650.0 мянган төгрөг, нийт 2 актаар 1,912.6 мянган төгрөгийн илүү олгосон цалин, нэмэгдлийн төлүүлэх төлбөрийн акт тавьсан байна.

Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/02 дугаар тушаалаар дотоод хяналт, шалгалтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу 10 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад аймгийн хэмжээнд 2013 онд нэгдсэн журмаар хийлгэсэн 453 хуудас бүхий НБББББ байдаг боловч хүчингүй болсон анхан шатны маягтуудтай, өөрчлөлт шинэчлэлтийг хийгээгүй бөгөөд өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,994,593.9 мянган төгрөгөөр буюу 149,8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,000.0	7,000.0	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	149,298.7	73,093.5	(76,205.2)
Үндсэн хөрөнгө	1,175,008.8	3,245,807.9	2,070,799.1
Нийт хөрөнгө	1,331,307.5	3,325,901.4	1,994,593.9
Өр төлбөр	-	935,262.2	935,262.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,331,307.5	2,390,639.2	1,059,331.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,331,307.5	3,325,901.4	1,994,593.9

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант оны эхэнд байсан 7,000.0 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй байна. Энэ нь өмнөх оны үлдэгдэл 7000.0 мянган төгрөгийн Хүүлээ хааны Хишиг ХХК -аас авах өвсний авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Бараа материал дансны хувьд түлш, шатах тослох материал 250,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материал 51,006.8 мянган төгрөг, аж ахуйн материал 22,005.7 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 3,389.0 мянган төгрөг, бичиг хэргийн хэргийн материал 53.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 1,566,018.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 129,935.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 374.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 27,236.2 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 353,388.3 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 44,142.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 22,397.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,566,018.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 7,230.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,270.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 79,390.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 44,142.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 133,819.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 9,124.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 275,499.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,390,639.0 мянган төгрөг болж 1,059,332.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,833,156.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 838,951.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 2,672,107.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 2,672,107.9 мянган төгрөгт 1 удаа тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,405,742.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 1,402,272.4 мянган төгрөгийг зарцуулж 3,470.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,402,272.4 мянган төгрөг буюу 52,48 хувьтай байна. Энэ нь ЗДТГ-ын барилга угсралтын ажлын шилжих үлдэгдлээс болон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ажлын санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	475,171.9	440,960.0	34,211.9	92.80%
2		80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	14,319.3	14,237.8	81.5	99.43%
3		80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	60,428.2	56,384.6	4,043.6	93.31%
4		80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,000.0	2,000.0	0.0	100.00%
5		80918-Бусад	1,770,692.5	871,810.4	898,882.1	49.24%
6		81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.0	100.00%
7		82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100.00%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	336,496.0	3,879.6	332,616.4	1.15%
9		82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	3,000.0	3,000.0	0.0	100.00%
Дүн			2,672,107.9	1,402,272.4	1,269,835.5	52.48%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Статистикийн хэлтсээс мал тооллогын зардал болон бусад судалгаануудад 1,021.5 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл 20,539.6 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 15,950.5 мянган төгрөг, гэр хорооллын айл өрх, халаалтын системд холбох ажлын санхүүжилт 65,574.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамж А/489 тоот захирамжаар санхүүгийн дэмжлэг, нийт 113,085.6 мянган төгрөгийн орлого орсноос цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 16,634.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 87,396.8 мянган төгрөг, нийт 104,031.4 мянган төгрөгийг зарцуулж, 9,054.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлнэ.	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 59.8 %	2,332,611.9	1,395,392.8
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 2.0 %	339,496.0	6,879.6

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр урсгал зардал болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 282,098.6 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 282,098.6 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Харин зарим шууд худалдан авалтыг хийхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний 02/16 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зарлага болох 2,672,107.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 40,081.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 30,061.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газар багуудын түлш халаалтын зардлыг хэмнэж 6.039.5 мянган төгрөгийн хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 42, зарлагын 32 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 34 шийдвэрийг хугацаандаа байршуулж, байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл,

байршуулаагүй 2 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 157 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 98,7 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлэхээс 2 мэдээлэл дутуу байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газарт завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 төлбөрийн акт тогтоосныг 97,9% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 01/124 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн шийдвэрлэлт	Өмнөх он		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	7,000.0	-	-	-
Зөвлөмж	1	324,437.2	1	324,437.2	100.0
Нийт дүн	2	331,437.2	1	324,437.2	97.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар хөрөнгийн түрээсийн болон төслийн хэрэгжилтийн зарцуулалтыг давтан шалгах асуудлыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,518,944.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,518,944.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан дүн мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлаас 744,409.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг зэрэгцүүлэн тулгахад цалин хөлс нэмэгдэл урамшил 4,628.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,628.6 мянган төгрөгөөр, тогтмол зардал 250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Сумын ЗДТГ-ын барилгад 2023 онд 630,755.9 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд улсын комиссын актаар хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Шинэ хөдөө төслийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам Грийн Капитал ХХК-тай байгуулсан гэрээгээр нийлүүлэгдсэн ерэн морины хүчтэй трактор, үр тарианы үрлүүр, хаман боогч нийт 133,818.6 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан боловч данс бүртгэл тусгаагүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5. Тайлант онд 5 ААН, иргэнээс худалдаж авсан 5,081.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 443,641.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 21,479.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 202,919.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 13,500.0 мянган төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлага, 205,742.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгч шийдвэрлэсэн байна.

5.2 Төлбөрийн акт

1. Батлагдсан цалингийн зардлын төсвөөс зарцуулагдаагүй 3,904.9 мянган төгрөгийн үлдэгдлийг ерөнхий дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Төрийн улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг эхний сард олгосон, гадаадад байгаа /ажиллаагүй/ албан хаагчид 12 сард цалин олгосон, СХАА-аас тавьсан актыг төсвөөс төлсөн, ЗГ-ын тэмдэглэлээр 100 хувийн цалинг ажилласан үр дүнтэй нь харгалзалгүй илүү олгосон зэрэг 17,154.8 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллагын дансанд бүртгэлтэй 0200 УНӨ дугаар бүхий Прадо120 маркийн машин нь тус байгууллагын эзэмшилд шилжүүлж аваагүй, 2019 оноос хойших 20 удаагийн үйлдлээр 420.0 мянган төгрөгийн торгууль тавигдсаныг төлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх” болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

1. Сум байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан төсвийн хөрөнгөнөөс 100 жилийн ойн медаль тэмдэг авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 24.7-д “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Шинэ хөдөө төслийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам Грийн Капитал ХХК-тай байгуулсан гэрээгээр нийлүүлэгдсэн ерэн морины хүчтэй трактор, үр тарианы үрлүүр, хаман боогч хүлээн авч хөрөнгийг түрээсээр ашиглуулсан гэрээний үр дүнг тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ төлбөрийн цахим баримтын дүнтэй тулгалт хийхэд ебаримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 115,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

4. Мөнгөн хөрөнгийн данснаас зардал гаргахдаа батлагдсан хөрөнгийн зардлаас бараа материал авсан, бараа ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэж нийт 87,919.5 мянган төгрөгийг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 22.2-д “Төсвийг дор дурдсаны дагуу ангилна”, 22.2.3-д “Эдийн засгийн ангиллаар”, Сангийн Сайдын 2021 оны 190 тоот тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал батлах заавар” болон санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад асуудал

1.1. Илрүүлэлт:

Газрын албаны мэдээлэлтэй тулган шалгахад ЗДТГ-ын 9 нэгж талбар бүхий газраас 7 газар бүртгэлгүй, 1 газрын гэрээг сунгаагүйгээс хүчингүй болсон, дансанд бүртгэлтэй 352.0 мянган төгрөгийн газар эзэмших эрх бүртгэсэн нь Засгийн газрын 2018 оны 182 тоот тогтоолоор үнэлж бүртгээгүйгээс 78,080.0 мянган төгрөг дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшилд байх газрын кадастрын зургийг авч, санхүүгийн тайлангийн биет хөрөнгийн дансанд газрын нэршил, газрын хэмжээ, үнэлгээг үндэслэн бүртгэж авах

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.2.1.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.2.Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрэн бүрдүүлж ажиллах

2.2.1.Илрүүлэлт:

Нийтийн эзэмшлийн байгууламжийн ногоон байгууламжийг үндсэн хөрөнгийн бусад хөрөнгөнд бүртгэж 18,926.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан, бусад хангамжийн материалд 16,088.0 мянган төгрөгөөр бүртгэсэн зэрэг зөрчилтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл” 4.35-д “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Нягтлан бодох бодлогын баримт бичиг зааснаар бүртгэж тайлагнах

3.2.1.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдэл, жилийн эцсийн тооллогын дүнгээс 7,574.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2.Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, бараа материалын хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, баримт бичгийг бүрдүүлж, тооллогын комисс ажиллуулах

4.2.1.Илрүүлэлт:

ОНХС-ийн хөрөнгөөр болон шинэ хөдөө төслийн хуц, хурган хуц, төлгөн хуцыг гэрээгээр эзэмшүүлсэн эсэх нь тодорхойгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Ангилал", "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2.Өгсөн зөвлөмж:

ОНХС-ийн хөрөнгөөр болон шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжиж буй хуц, хурган хуц, төлгөн хуцыг малчдад гэрээгээр эзэмшүүлж, гэрээг дүгнэж баримтжуулж авах

5.2.1.Илрүүлэлт:

Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн халаалтын системд холбоход Ингүүмэл эрчим ХХК-д 65,574.0 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд ажлыг данс бүртгэл тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.2.Өгсөн зөвлөмж:

Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн халаалтын системд холбох ажлын гүйцэтгэл, улсын комиссын акт зэрэг холбогдох баримт материалыг үндэслэн орлого авах

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.3.1.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлэхээс 2 мэдээлэл дутуу байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай

мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” гэж заасны дагуу дансны хуулганаас бүрэн татаж оруулж мэдээлсэн эсэхийг давтан хянан баталгаажуулж байх

3. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

2.3.1.Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3.2.Өгсөн зөвлөмж:

Ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	1	115,000.0	-	-	1	115,000.0	-	-	-	-	-	-
Хөрөнгийн зардлаас бараа материал бэлтгэсэн мөн бараа ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна.	1	87,919.5	-	-	1	87,919.5	-	-	-	-	-	-
Шинэ хөдөө төслийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам Грийн Капитал ХХК-тай байгуулсан гэрээгээр нийлүүлэгдсэн ерөн морины хүчтэй трактор, үр тарианы үрлүүр, хаман боогч хүлээн авч хөрөнгийг түрээсээр ашиглуулсан гэрээний үр дүнг тайлагнаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр 100 жилийн ойн медаль тэмдэг авсан байна.	1	13,500.0	-	-	-	-	-	1	13,500.0	-	-	-
Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад аж ахуйн материал 7,574.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилгодсон тооллогын комисс нь тооллого хийсэн гэх боловч тоологдсон хөрөнгийг дүгнээгүй, тооцоо бодсон гэх боловч хөрөнгө зөрүүтэй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна.	1	7,574.8	-	-	-	7,574.8	-	-	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Гэр хороололын айл өрх, үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн халаалтын системд холбоход Ингүүмэл эрчим ХХК-д шилжүүлсэн бөгөөд ажлыг хүлээн авсан актгүй данс бүртгэл тусгаагүй байна.	1	65,574.0	-	-	-	65,574.0	-	-	-	-	-	-
ОНХ-ийн хөрөнгөөр болон шинэ хөдөө төслийн хуц, хурган хуц, төлгөн хуцыг гэрээгээр эзэмшүүлсэн эсэх нь тодорхойгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй байна.	1	19,500.0	-	-	-	19,500.0	-	-	-	-	-	-
Газрын албаны мэдээлэлтэй тулган шалгахад ЗДТГ-ын газрын 9 нэгж талбар бүхий газраас 7 газар бүртгэлгүй, 1 газрын гэрээг сунгаагүйгээс хүчингүй болсон, дансанд бүртгэлтэй 352.0 мянган төгрөгийн газар эзэмших эрх бүртгэсэн нь Засгийн газрын 2018 оны 182 тоот тогтоолоор үнэлж бүртгээгүйгээс 78,080.0 мянган төгрөг байна.	1	78,080.0	-	-	-	78,080.0	-	-	-	-	-	-
Нийтийн эзэмшлийн байгууламжийн ногоон байгууламжийг үндсэн хөрөнгийн бусад хөрөнгөнд бүртгэж 18.926.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан, бусад хангамжийн материалд 16,088.0 мянган төгрөгөөр бүртгэсэн зэрэг зөрчилтэй байна.	1	35,014.0	-	-	-	35,014.0	-	-	-	-	-	-
Машины дугаарын тусгай тэмдэглэгээг хийгээгүй. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэснийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Дүн	14	443,641.8	3	21,479.5	3	202,919.5	7	205,742.8	1	13,500.0	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
төгрөг/**

/мянган

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлэхээс 2 мэдээлэл дутуу байршуулсан байна.	1	-					1	-
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0